

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хархорум музейн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2023/231/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2023 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гондоржийн гудамж,
6 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 52173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn,
Цахим хуудал: www.audit.mn

2023.01.15 № 15
Танай _____-ны № _____-1

ХАРХОРУМ МУЗЕЙН ЗАХИРАЛ
Т.БАЯРАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорум музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хархорум музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9 болон 8 дугаар зүйлийн 8.2 дахь зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй. Тус байгууллага нь 2022 онд 508,125,600 төгрөгийн санхүүжилт авч, 11,830,632 төгрөг төвлөрүүлсэн, өөрийн ажил үйлчилгээний орлого 75,266,610 төгрөг, нэмэлт дансанд 74,886,422 төгрөгийн өөрийн орлого орж зарцуулагдсан байна.

Соёл урлаг хөгжүүлэх сангаас модон эдлэл сахрын уусмалын аргаар бэхжүүлэх төсөлд 30,000,000 төгрөг, үзмэр худалдан авах зориулалтаар 18,800,000 төгрөг тус тус орж ирсэн. Жилийн эцэст нэмэлт санхүүжилтийн данснаас 277,124 төгрөг татан төвлөрүүлсэн.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

01-03-15

Тус байгууллагад нь 34,164,783 төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 108,403,227 төгрөгийн хөрөнгө хандиваар нэмэгдэж балансад бүртгэсэн байна.

ТӨБЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 29-ны 427 тогтоолоор элэгдэл нь зардлаа нөхсөн 136,516,636 төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлж 66,354,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн, 8,544,964 төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт		2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	100.9	119.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4485.9	4602.9
	Нийт хөрөнгийн дүн	4586.9	4722.4
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4586.9	4722.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4586.9	4722.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	492.1	807.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	565.9	671.9
	Үйл ажиллагааны үр дүн	-73.8	135.4
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-73.8	135.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327.6	327.6
	Тайлант оны үр дүн	5396.2	135.4
	Эцсийн үлдэгдэл	4586.9	4722.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	482.2	632.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	482.0	598.0
	Үйл ажиллагааны ЦМГ	0.2	0.034
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-0.2	-0.034
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	508.1	496.3
	Урсгал зардал	508.1	496.3
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	508.1	508.1
	Улсын төсвөөс санхүүжих	508.1	508.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхоны хөндий дэх түүх, соёлын өвийн судалгаа, сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалт, түгээн дэлгэрүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж, инновацыг нэвтрүүлэгч, үзэгч төвтэй музей байна.

Хархорум музейн Захиргаа-үйлчилгээ, Судалгаа-үзүүллэг зохион байгуулалт, Сан хөмрөг-бүртгэл, мэдээллийн алба, нийт 31 хүний орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нэмэлт дансанд тушаагдсан орлого болон дээд шатны байгууллагуудаас олгогдсон санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын дагуу зарцуулах эрхийг тавиулан зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт харилцах дансанд нийт 124.1 сая төгрөг орсноос, өөрийн орлого 74.9 сая төгрөг, Соёл урлаг хөгжүүлэх сангаас модон эдлэл сахрын уусмалын аргаар бэхжүүлэх төсөлд 30.3 сая төгрөг, Соёл урлагийн газраас үзмэр худалдан авах зориулалтаар 18.8 сая төгрөг орж зарцуулагдсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэсэн.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Хархорум музей нь 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг FAS системийн шилэн дансны мэдээллийн дагуу шалган тулгасан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 100 хувь байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төвийн хөрөнгө зарцуулсан эсэхийг тулган шалгах.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3.3 сая төгрөгийн зөрчил илэрч 3.3 сая төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Түлш халаалтын зардлаас ажилчдад 34.8 тн буюу 3306.0 мянган төгрөгийн нүүрс олгосон зөрчилд албан шаардлага өгсөн.

Зөвлөмж-1 Үндсэн ажил үүргээ гүйцэтгэж байгаа боловч хагас бүтэнд сайнд ажилласан албан хаагчдад хоёр өдрийн цалин хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлж 609.0 мянган төгрөгийн илүү цаг олгосон байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	3.9					1	3.3	1	0.6
	НИЙТ										

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

